



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 09

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн Музейн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 7 нэр төрлийн 1,241,385 /нэг сая хоёр зуун дөчин нэгэн мянга гурван зуун наян тав/ төгрөгийн анхны өртөгтэй, 219,825 /хоёр зуун арван есөн мянга найман зуун хорин тав/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хөрөнгийг хавсралтын дагуу актлан устгахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу устгаж, данс бүртгэлээс хасахыг Дундговь аймгийн Музейн дарга М.Бямбажавт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 сарын 24 өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт

Актлаж устгах хөрөнгө

№	Хөрөнгийн нэр	Ашигласан жил	Тоо хэмжээ	Анхны өртөг	Элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	SCX-4200 принтер	9	1	130,000	130,000	0
2	Сүлжээний бахь	9	1	9,000	9,000	0
3	Сандал	6	4	20,000	20,000	0
4	Алт мөнгөний дэнс	14	1	253,260	253,260	0
5	Диван кресло	9	1	299,145	299,145	0
6	Буйдан	8	1	250,000	137,499	112,500
7	Тоос сорогч	6	2	279,980	172,654.25	107,325.75
Нийт дүн				1,241,385	1,021,559.25	219,825.75